

**МОНГОЛ УЛСЫН 2009 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргалаа. 2009 оны эхний хагас жилийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийт орлого 826.3 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 5.9 тэрбум төгрөгөөр буюу 0.7 хувиар дутуу биелж, 2008 оны мөн үеийнхээс 20.0 хувиар буюу 206.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрээр нь авч үзвэл 78.2 хувь нь татварын орлогоос, 21.6 хувь татварын бус орлогоос, хөрөнгийн орлогоос 0.2 хувь нь тус тус бүрдсэн байна. Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл нь аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар 21.4 хувиар буюу 20.3 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татвар 2.6 хувиар буюу 3.9 тэрбум, гадаад худалдааны орлого 7.0 хувиар буюу 4.1 тэрбум, бусад татварын орлого 8.9 хувиар буюу 6.8 тэрбум, хөрөнгийн орлого 44.0 хувиар буюу 1.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэнтэй холбоотой байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

ТӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	2009 ОНЫ ЭХНИЙ ХАГАС Төлөв.	ХУВЬ Гүйцэт.	ХУВЬ (4:3)	ӨРҮҮ (4:2)	ӨРҮҮ (4-3)
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,033.2	1,972.9	832.2	826.3	99.3	41.9	-5.9
УРСГАЛ ОРЛОГО	1,029.7	1,948.5	823.1	824.9	100.2	42.3	1.8
ТАТВАРЫН ОРЛОГО	907.0	1,618.6	646.1	646.0	100.0	39.9	0.0
Орлогын албан татвар	382.4	372.8	162.8	164.3	100.9	44.1	1.5
ААН-ийн орлогын албан татвар	133.7	223.5	94.6	74.3	78.6	33.3	-20.3
Хувь үний орлогын албан татвар	50.8	98.7	52.0	58.7	112.9	59.5	6.7
Зарим ҮТЭЭГДЭХҮҮНИЙ үнийн өсөлтийн албан татвар	197.9	50.7	16.3	31.3	192.8	61.8	15.1
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	98.7	251.6	107.6	117.8	109.5	46.8	10.2
Өмчийн татвар	4.3	10.3	5.1	5.1	99.0	49.1	-0.1
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	249.6	629.3	234.7	233.9	99.7	37.2	-0.8
Гадаад худалдааны орлого	73.0	163.2	58.7	54.6	93.0	33.5	-4.1
Бусад татвар	99.0	191.5	77.1	70.3	91.1	36.7	-6.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	122.7	329.9	177.1	178.9	101.0	54.2	1.8
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	2.1	2.4	2.5	1.4	56.0	59.8	-1.1
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1.4	22.0	6.6	0.0	0.0	0.0	-6.6

Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлтийг төсөв тус бүрээр авч үзвэл:

Улсын төсвийн орлого

УИХ-аас баталсан Монгол улсын төсвийн орлого 2009 оны эхний хагас жилийн байдлаар 652,8 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 619,1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч 5.2 хувиар буюу 33.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу биелсэн байна. Тухайлбал ААНОАТ-ын орлого 20,3 тэрбум төгрөгөөр, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар 18,8 тэрбум

тегереер, гадаад худалдааны орлого 4,1 тэрбум тегереер, улсын тэмдэгтийн хураамж 11.4 тэрбум тегереер тус тус тасарсан байна.

Төлөвлөгөө тасалдсан шалтгаануудын авч үзэхэд уул уурхайн болон барилгын салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон, нүүрсний уурхайнууд, эрчим хүчний систем, нефть хангамжийн компаниудын хоорондссэн өр авлага, төлбөрийн чадварын доройтол бодитойгоор нөлөөлсөн байна.

Татварын орлогыг татварын нэр төрөл тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар:

Улсын төсөвт 2009 оны эхний хагас жилийн байдлаар аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвараар 94,6 тэрбум тегрег батлагдсанаас 74,3 тэрбум тус тус нь төлөвлөснөөс 21,4 хувиар буюу 20,3 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Томоохон аж ахуйн нэгжүүдээс авч үзвэл:

1. Төсвийн орлогын төлөвлөгөө Голомт банк 541,7 сая тегереер, Дарханы темерлегийн үйлдвэр 843,7 сая тегереер, ХААНБанк 2398,9 сая тегереер, Бороо гоулд 486,9 сая тегереер, Цайртминерал 482,4 сая тегереер, НИК 542,0 сая тегереер, Эрдэнэгазар 4030,3 сая тегереер, Эрдмин ХХК 1308,7 сая тегереер, Мобиком ХХК 2321,9 сая тегереер тус тус тасарчээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвар:

Нэмэгдсэн өртгийн албан татвараар 147,5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгдсөнөөс 143,7 тэрбум төгрөг төвлөрч 3,9 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Үүнээс Дотоодын бараа, ажил үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 11,4 хувиар буюу 7,4 тэрбум төгрөгөөр давж биелж улсын төсөвт 72,2 тэрбум төгрөг, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 15,3 хувиар буюу 18,8 тэрбум төгрөгөөр тасарч улсын төсөвт 103,9 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

НӨАТ-ын буцаан олголтын санд 40,0 тэрбум төгрөг төсөвлөснөөс 32,4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 7,6 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна

Онцгой албан татвар:

Онцгой албан татварын орлогыг 76,7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 78,9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 2,3 тэрбум төгрөгөөр буюу 2,9 хувиар төлөвлөгөө давж биелсэн байна. Дотоодын архины онцгой албан татвараар 25,4 тэрбум тегрег батлагдсанаас 26,7 тэрбум тегрегийн гүйцэтгэл гарч 1,3 тэрбум тегереер, дотоодын тамхины онцгой албан татвар 4,9 тэрбум тегереер батлагдсанаас 5,0 тэрбум тегрегийн гүйцэтгэл гарч 0,1 тэрбум тегереер, авто бензин дизелийн тилшний онцгой албан татвар 21,1 тэрбум тегереер батлагдсанаас 22,1 тэрбум тегрегийн гүйцэтгэл гарч 1,0 тэрбум тегереер, импортын архи тамхины онцгой албан татвар 7,4 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 7,8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч 0,5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Онцгой татвартай барааны импортын тоо хэмжээний өсөлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл согтууруулах ундаа 35,6 хувиар буюу 3223,8 мян.л итрээр буурсан байна. Үүний дотор шар айраг 38,0 хувиар буюу 3234,6 мянган литрээр буурч дарс 1,2 хувиар буюу 6,3 мянган литрээр тус тус буурч, архи виски 2.5 дахин буюу 17,0 мянган литрээр өссөн байна.

Нефть бүтээгдэхүүн тонн хэмжээгээрээ өнгөрсөн оны мөн үеэс 15,9 хувиар буюу 51,4 мянган тонноор буурснаас 90 үртэл октантай автобензин 37,8 мянган тонноор, дизелийн түлш 19,9 мянган тонноор тус тус буурч, 90-ээс дээш октантай автобензин 10,5 хувиар буюу 6,4 мянган тонноор өссөн байна.

Суудлын автомашины импорт 69,3 хувиар буюу 11626 ширхэгээр өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна.

Ашигт малтмалын нөөцийн төлбөрийн орлогыг төвлөрүүлэгч байгууллагаар авч үзвэл:

	/сая. төг/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1 Эрдэнэт УИГ	9892,0	8949,5	90,4
2 Тавантолгой	1232,0	3700,0	300,3
3 Бороо гоулд	3112,5	2961,5	95,1
4 Цайрт минерал	1471,0	1113,9	75,7
5 Бусад	3572,0	7660,4	214,5
Нийт дүн	19279,5	24385,3	126,5

Татварын бус орлого:

Татварын бус орлогыг 165,4 тэрбумтөгрөгөөр төлөвлөснөөс 167,3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 1,9 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Төрийн өмчийн ногдол ашгийн орлогоор Эрдэнэт УБ -ээс 84,5 тэрбум өгрөг төвлөрүүлсэн нь татварын бус орлогын 50,5 хувийг эзэлж байна

Тусламжийн орлого:

Тусламжийн орлого 67,7 тэрбумтөгрөгөөр төлөвлөгдснөөс 61,3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 6,4 тэрбум төгрөгөөр тасарчээ. Үүнээс Орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого 101 хувийн биелэлттэй гарсан бол улсын эмнэлгүүдэд олгох Эрүүл мэндийн даатгалын орлого 23,1 тэрбумтөгрөгөөр төлөвлөгдсөнөөс 23,0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч 0,1 тэрбум төгрөгөөр тасарсан нь тусламжийн орлогын тасралтанд шууд нөлөөлжээ.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулвал:

ТӨСВИЙН ОРЛОГО	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		МУХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.өгрөг)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	652.8	619.1	125.9	127.9	16.6	32.3	227.4	234.8
УРСГАЛ ОРЛОГО	585.1	557.7	113.9	117.1	16.6	32.3	142.7	150.1
ТАТВАРЫН ОРЛОГО	419.7	390.4	102.6	106.5	16.3	31.3	142.7	150.1
Орлогын албан татвар	94.6	74.3	52.0	58.7	16.3	31.3	0.0	0.0
ААН-ийн орлогын албан татвар	94.6	74.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь үний орлогын албан татвар	0.0	0.0	52.0	58.7	0.0	0.0	0.0	0.0
Зарим өгээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	0.0	0.0	0.0	0.0	16.3	31.3	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	142.7	150.1
Өмчийн татвар	0.0	0.0	5.1	5.1	0.0	0.0	0.0	0.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	227.5	225.7	7.2	8.2	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	58.7	54.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	38.8	35.8	38.3	34.5	0.0	0.0	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	165.4	167.3	11.4	10.6	0.3	1.0	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	2.5	1.4	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	67.7	61.3	9.4	9.4	0.0	0.0	84.7	84.7

- Орон нутгийн төсвийн орлого 1.6 хувиар буюу 2.0 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Өмнөговь аймгийн лицензийн төлбөрийн орлого 1.3 тэрбум, хувьцааны ноогдол ашгийн орлого 0.7 тэрбум тус тус тасарч аймгийн нийтүдгээр 1.4 тэрбум төгрөгөөр, Орхон аймгийн ашигт малтмал ашигласны нөөцийн төлбөр 3.9 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн бол Увс аймгийн орлого 0.4 тэрбум, өв аймгийн орлого 0.6 тэрбум, Сүхбаатар аймгийн орлого 0.9 тэрбум төгрөгөөр, нийслэл Улаанбаатар хотын орлого 3.6 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

- Монгол Улсыг өгжүүлэх сангийн орлого д зарим бүтээгдэхүүний үний өсөлтийн татварын орлого 31.3 тэрбум төгрөг төвлөрсөн. Нийгмийн даатгалын сангийн орлого 234.8 тэрбум төгрөгт хүрч 3.2 хувиар буюу 7.4 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлжээ. Нийгмийн даатгалын санд улсын өсвөөс олгох 84.7 тэрбум төгрөгийн татаас, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт: Монгол Улсын нэгдсэн өсвийн 2009 оны эхний хагас жилийн нийт зарлага 1367.9 тэрбум төгрөг, үүнээс улсын төсвийн зарлага 1085.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр нэгдсэн өсвийн зарлага 1087.6 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлагын 79.5 хувийг, улсын өсвийн зарлага 892.0 тэрбум төгрөг болж, нийт өлөвлөгдсөн зардлын 82.1 хувийг санхүүжүүлсэн байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн тавьж олгосон бөгөөд халамжийн сангаас хүүхдийн мөнгөний хөтөлбөрт 27.8 тэрбум төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжинд 3.3 тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламжинд 8.9 тэрбум төгрөг, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 7.6 тэрбум төгрөг, алдар цолтой ахмадууд олгох нэмэгдэл, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлтөнд нийт 3.2 тэрбум төгрөг, жирэмсэн нярай эхчүүдэд 7.8 тэрбум төгрөгийн халамжийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Нэгдсэн төсвийн нийт урсгал зардлын 13.0 хувь буюу 112.0 тэрбум төгрөг нь нийгмийн халамжийн сангийн зардал, 38.4 хувь буюу 330.5 тэрбум төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нийтдээ 51.4 хувь буюу 442.5 тэрбум төгрөг нь цалин, тэтгэвэр тэтгэмжийн зардал эзэлж байна.

Орон нутгийн өсвийн зарлага 101.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардлын 86.3 хувийг санхүүжүүлсэн байна. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зарлага төлөвлөгдсөн зардлын 47.1 хувь буюу 64.9 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн зарлагын төлөвлөгдсөн зардлын 99.9 хувь буюу 217.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

ӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үсийн	жилийн Төлөв.	2009 ОНЫ ЭХНИЙ ХАГАС		ХУВЬ		ӨРҮҮ (4 - 3)
			Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,038.1	2,314.2	1,367.9	1,087.6	79.5	47.0	-280.3
УРСГАЛ ЗАРДАЛ	838.2	1,784.7	1,021.8	860.3	84.2	48.2	-161.4
Бараа, үйлчилгээний зардал	476.1	931.9	541.9	480.8	88.7	51.6	-61.1
Цалин хөлс	270.7	586.6	322.0	302.3	93.9	51.5	-19.7
Нийгмийн даатгалын шимтгэл	24.2	55.7	31.0	28.2	91.0	50.7	-2.8
Бараа, үйлчилгээний бусад зардал	205.4	345.3	219.9	178.5	81.2	51.7	-41.4
Зээлийн үйлчилгээний төлбөр	10.2	54.5	15.1	13.8	91.4	25.3	-1.3
Татаас ба шилжүүлэг	351.8	798.3	464.7	365.7	78.7	45.8	-99.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	150.2	428.1	301.0	109.9	36.5	25.7	-191.1
Дотоод эх үүсвэрээр:	148.7	396.1	286.6	99.9	34.9	25.2	-186.7
Гадаад эх үүсвэрээр	1.4	32.0	14.4	10.0	69.4	31.1	-4.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	49.7	101.4	45.2	117.4	260.0	115.8	72.2
УРСГАЛ ТЭНЦЭЛ	191.5	163.8	-198.7	-35.4	17.8	(21.6)	163.2
НИЙТ ТЭНЦЭЛ	-4.8	-341.3	-535.7	-261.3	48.8	76.5	274.4

Эргэж төлөгдөх цэвэр зээл :

Монгол Улсын Засгийн газар 2009 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр гадаадын хандивлагч орнуудаас 69.5 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төслийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 35.9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх

үүсвэрийг авч ашигласан гүйцэтгэл гарчээ.

Төсвийн тэнцэл:

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 35.4 тэрбум, нийт тэнцэл 261.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 145.2 тэрбум, нийт тэнцэл 272.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Төсвийн нийт алдагдлыг дараах байдлаар санхүүжүүлэхээр

1. Засгийн газрын бонд гаргаж 60.0 тэрбум төгрөгийн,
2. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн эрсдлийн хэсгээс 89.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрүүдийг бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

Орон нутгийн орлогын өлөвлөгөө 1.6 хувиар буюу 2.0 тэрбум өгрөгөөр төлөвлөгөөнөөс давж төвлөрсөн байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгт 9.4 тэрбум өгрөг ийг бүрэн олгосон байна. Улсын төсөвт орон нутгаас нийт 38.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 38.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлого, зарлагын гүйцэтгэл:

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн хүрээнд 2009 оны эхний хагас жилд 0-18 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид зориулан 28.9 тэрбум, хөрөнгө оруулалтанд 84.4 тэрбум, улсын өцн бүрдүү лэхэд 2.4 тэрбум өгрөг ийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлжээ.

-----oOo-----